



**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

# **ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭЛЭЛ**

**Дугаар 2019/12**

**Улаанбаатар хот  
2020 он**

## ГАРЧИГ

Агуулга	Хуудасны дугаар
1. Аж үйлдвэр	2
2. Мал аж ахуй	4
3. Газар тариалан	15
4. Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ	17

Үндэсний статистикийн хорооны албан ёсны мэдээг ашиглав.

## 1.АЖ ҮЙЛДВЭР



**Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр 17.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 1.8 (11.2%) их наяд төгрөгөөр өслөө.** Үүнд, уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 1.2 (11.1%) их наяд төгрөгөөр, боловсруулах аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 351.8 (10.5%) тэрбум төгрөгөөр, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарын үйлдвэрлэл 156.5 (15.0%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлөв.

АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, 2019\* оны эцсийн байдлаар



Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлийн 71.8 хувийг уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбар, 21.3 хувийг боловсруулах аж үйлдвэрийн салбар, 6.9 хувийг цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбар эзэлж байна.



Боловсруулах аж үйлдвэрийн салбарт 2019 онд өмнөх оноос шингэн сүү, ус, ундаа, жүүс, цемент, ноолууран сүлжмэл эдлэл, шохой, нүүрсэн шахмал түлш зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 5.7 хувиас 108.6 дахин өссөн байна.

Харин боловсруулах аж үйлдвэрийн салбарт гурил, согтууруулах ундаа, металл бэлдэц, баяжуулсан нүүрс, металл цувимал, тамхи, катодын зэс, малын мах, самнасан ноолуур зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 1.0-33.3 хувиар буурсан байна.

### Боловсруулах аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2018 он		2019* он		<u>2019* I-XII</u>	
		XII	I-XII	XII	I-XII	<u>2018 I-XII</u>	
							хувь
Малын мах	т	11 489.5	45 221.7	5 620.9	31 728.1	70.2 ▼	
Шингэн сүү	мян.л	3 402.0	38 253.2	4 225.3	40 448.9	105.7 ▲	
Гурил	т	23 767.9	210 965.4	26 840.9	208 932.7	99.0 ▼	
Согтууруулах ундаа	мян.л	9 829.7	130 740.2	11 150.6	129 273.7	98.9 ▼	
Ус, ундаа, жүүс	мян.л	22 501.5	304 856.9	26 133.2	337 952.6	110.9 ▲	
Тамхи	мян.блок	555.8	4 721.5	134.3	3 944.4	83.5 ▼	
Ноолууран сүлжмэл эдлэл	мян.ш	174.5	1 461.3	131.8	1 729.6	118.4 ▲	
Самнасан ноолуур	т	41.2	1 160.3	41.2	774.0	66.7 ▼	

<sup>1</sup> Дахин их

**Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр 20.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 1.8 (9.8%) их наяд төгрөгөөр өслөө.** Үүнд, уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулалт 970.6 (7.7%) тэрбум төгрөгөөр, боловсруулах аж үйлдвэрийн салбарын борлуулалт 660.7(14.5%) тэрбум төгрөгөөр, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарын борлуулалт 158.0 (15.1%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

**Нийт борлуулсан бүтээгдэхүүний 13.6 их наяд төгрөг буюу 67.6 хувийг гадаад зах зээлд борлуулжээ.** Үүнээс, уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын гадаад борлуулалт 11.3 (83.4%) их наяд төгрөг, боловсруулах аж үйлдвэрийн салбарын гадаад борлуулалт 2.3 (16.6%) их наяд төгрөг байна.

### Аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн, салбараар, сараар, тэрбум төгрөг

Салбар	2018 он		2019* он			<u>2019* I-XII</u>
	XII	I-XII	XII	I-XII	Үүнээс гадаадад	<u>2018 I-XII</u>
	сая төгрөг					хувь
<b>Нийт дүн</b>	<b>1 848.1</b>	<b>18 298.4</b>	<b>1 694.9</b>	<b>20 087.7</b>	<b>13 570.0</b>	<b>109.8</b>
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	1 317.1	12 684.8	1 078.1	13 655.4	11 318.6	107.7
Боловсруулах аж үйлдвэр	419.7	4 564.5	486.3	5 225.2	2 251.4	114.5
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	111.4	1 049.1	130.6	1 207.1	-	115.1

## 2.МАЛ АЖ АХУЙ




Улсын хэмжээгээр 2019 оны эцэст, мал тооллогын урьдчилсан дүнгээр 71.0 сая толгой мал, үүнээс 4.2 сая адуу, 4.8 сая үхэр, 472.4 мянган тэмээ, 32.3 сая хонь, 29.3 сая ямаа тоологдов.

	Малын тоо				Өөрчлөлт	
	2016	2017	2018	2019	тоо	хувь
					толгой	
Нийт	61.5	66.2	66.5	71.0	4.5	106.8
Адуу	3.6	3.9	3.9	4.2	0.3	107.0
Үхэр	4.1	4.4	4.4	4.8	0.4	108.5
Тэмээ	0.4	0.4	0.5	0.5	0.0	102.8
Хонь	27.9	30.1	30.6	32.3	1.7	105.6
Ямаа	25.6	27.3	27.1	29.3	2.1	107.9

Малын нийт тоо өмнөх оноос 4.5 сая (6.8%), үүнээс ямаа 2.1 сая (7.9%)-аар, хонь 1.7 сая (5.6%), үхэр 372.3 мянга (8.5%), адуу 274.7 толгой (7.0%), тэмээ 12.7 мянган толгойгоор (2.8%) тус тус өссөн байна.

### Мал сүргийн бүтэц, нийт сүрэгт эзлэх хувиар

Нийт мал сүргийн дотор 2019 оны тооллогын дүнгээр хонь 45.5 хувь, ямаа 41.2 хувь, үхэр 6.7 хувь, адуу 5.9 хувь, тэмээ 0.7



хувийг эзэлж байна.

2019 онд нийт сүрэгт 5 төрлийн малын эзлэх хувийг мал хувийн өмчид шилжиж эхэлсэн 1990 онтой харьцуулахад ямааны эзлэх хувь 21.4 пунктээр өсөж, харин хониных 12.9 пункт, үхрийнх 4.3 пункт, адууных 2.8 пункт, тэмээнийх 1.4 пунктээр буурсан байна.

Манай улсын хонь, ямааны харьцаа 1990 он хүртэл 75:25 буюу 3 хонинд нэг ямаа ногдож, зохистой харьцааг хадгалж байсан.

Гэвч сүүлийн жилүүдэд сүргийн бүтцэд болон малын бэлчээр ашиглалтад зохистой энэ уламжлалт харьцаа алдагдсаар 25 орчим жил болж байна.

Тухайлбал, ямааны тоо толгойн мэдэгдэхүйц өсөлт 1993 оноос эхэлж, ноолуур үнэд орсонтой холбогдон 1994-2003 онд хонины тоотой ижил түвшинд болж, 2003-2009 оны ямааны тоо хонины тооноос давж, 2009-2015 онд хонины тоо толгойтой дүйцэж, 50:50 харьцаатай болсон байна.

Бог малд хонь ямааны эзлэх хувь 2019 онд 52:48 харьцаатай байна.

Улсын хэмжээнд 2019 онд оны эхний төллөх насны 29.8 сая хээлтэгч малын 24.9 сая (83.7%) нь төллөжээ. Гүүний 78.4 хувь, үнээний 81.9 хувь, ингэний 47.0 хувь, эм хонины 87.6 хувь, эм ямааны 80.5 хувь нь төллөсөн байна.

Төллөлтийн хувь өмнөх оноос 8.7 пункт, эм ямааных 11.1 пункт, гүүнийх 11.1 пункт, эм хониных 6.9 пункт, үнээнийх 5.8 пунктээр өсөж, ингэнийх 3.8 пунктээр буурсан байна.

2019 онд 23.6 сая толгой төл бойжуулж, бойжилтын хувь 94.4%-тай байна. Бойжуулсан төлийн тоо өмнөх оноос 4.2 сая толгойгоор, бойжилтын хувь 3.1 пунктээр тус тус өссөн байна.

Оны эхний малын 1.7 хувь буюу 1.1 сая том мал 2019 онд зүй бусаар хорогдлоо. Оны эхний малд хорогдлын эзлэх хувь Баруун бүсэд 2.7, Зүүн бүсэд 2.4, Хангайн бүсэд 1.4, Улаанбаатар хотод 1.1, Төвийн бүсэд 0.7 байна. Нийт хорогдсон малын 79.2 мянга (7.1%) нь өвчнөөр хорогдсон байна.

Нийт 1369.2 мянган тонн хадлан бэлтгэсэн нь өмнөх оноос 139.8 мянган тонн буюу 11.4 хувиар өссөн байна. Бэлтгэсэн хадланг аймгаар авч үзвэл Хөвсгөл, Сэлэнгэ, Дорнод, Баян-Өлгий, Өвөрхангай, Увс, Архангай, Дундговь, Завхан, Дорноговь, Булган, Сүхбаатар, Говь-Алтай, Орхон аймгууд болон Улаанбаатар хотод өмнөх оноос 0.4-60.3 мянган тонноор буюу 1.4 хувиас 4.2 дахин өссөн байна. Бусад аймагт өмнөх оноос 0.4-16.3 мянган тонноор буюу 5.0-51.6 хувиар буурчээ.

Хонин толгойд шилжүүлснээр хадлан, бэлчээрийн 100 га талбайд ногдох малын тоо 2019 онд 106 толгой болж, өмнөх оноос 7 толгойгоор өссөн байна. Энэ үзүүлэлт Орхон аймагт 715, Улаанбаатар хотод 519, Дархан-Уул аймагт 370, Архангай аймагт 319, Булган аймагт 253, Хөвсгөл аймагт 228 болж, улсын дунджаас 122-609 толгойгоор их байна.

Улсын хэмжээнд мал тооллогын урьдчилсан дүнгээр 233.3 мянган малтай өрх тооллогод хамрагдаж, өмнөх оноос 2.5 мянган өрхөөр буюу 1.1 хувиар өссөн байна. Малтай өрхийг малын тоогоор нь бүлэглэж үзэхэд 50 хүртэлх малтай өрх 4.2 хувиар, 51-200 хүртэлх малтай өрх 1.3 хувиар буурсан, 201-500 малтай өрх 1.7 хувиар, 501-999 малтай өрх 9.3 хувиар, 1000-2000 малтай өрх 14.4 хувиар, 2001-ээс дээш малтай өрх 11.0 хувиар өссөн байна.

## Малтай өрхийн бүлэглэлт, малын тооны бүлгээр, жил бүрийн эцэст

	Малтай өрхийн тоо				Малтай нэг өрхөд ногдох малын тоо			
	2016	2017	2018	2019	2016	2017	2018	2019
Бүгд	223 761	228 950	230 854	233 317	273	288	286	303
50 хүртэлх малтай	49 110	48 370	48 564	46 517	22	22	23	23
51-200	74 945	74 418	74 820	73 870	119	119	120	120
201-500	63 120	65 336	66 436	67 545	320	321	321	323
501-999	26 632	29 499	30 230	33 043	677	680	681	685
1000-2000	9 347	10 636	10 141	11 606	1 223	1 230	1 228	1 235
2001-ээс дээш малтай	607	691	663	736	2 493	2 524	2 519	2 539

Малтай нэг өрхөд ногдох малын тоо 2019 онд дунджаар 303 болж, өмнөх оноос 17 толгой мал буюу 5.9 хувиар өссөн байна. Малтай нэг өрхөд 18 адуу, 20 үхэр, 2 тэмээ, 137 хонь, 125 ямаа ногдож байна. Өмнөх оноос малтай нэг өрхөд ногдох адуу 1-ээр, үхэр 1-ээр, хонь 5-аар, ямаа 8-аар өсөж, тэмээний тоо өөрчлөлтгүй байна.

Мал тооллогын 2019 оны дүнгээр нийт малтай өрхийн 73.6 хувь буюу 171.6 мянган өрх нь жилийн дөрвөн улирлын туршид малаа маллаж, амьжиргааны эх үүсвэр нь болж байгаа малчин өрх байна. Малчин өрхийн тоо өмнөх оноос 1.9 мянга буюу 1.1 хувиар өслөө. Малчин өрхийг малын тоогоор нь бүлэглэж үзэхэд 50 хүртэлх малтай өрх 2.7 хувиар, 51-200 хүртэлх малтай өрх 3.4 хувиар буурсан байхад 201-500 малтай өрх 0.1 хувиар, 501-999 малтай өрх 9.0 хувиар, 1000-2000 малтай өрх 14.3 хувиар, 2001-ээс дээш малтай өрх 10.9 хувиар өссөн байна.

Малчин нэг өрхөд ногдох малын тоо 2019 онд дунджаар 370 болж, өмнөх оноос 19 толгой мал буюу 5.4 хувиар өссөн байна. Малчин нэг өрхөд 22 адуу, 23 үхэр, 3 тэмээ, 169 хонь, 153 ямаа ногдож байна. Өмнөх оноос малчин нэг өрхөд ногдох адуу 2-оор, үхэр 1-ээр, хонь 6-аар, ямаа 10-аар өсөж, тэмээний тоо өөрчлөлтгүй байна.

## Малчин өрхийн бүлэглэлт, малын тооны бүлгээр, жил бүрийн эцэст

	Малчин өрхийн тоо				Малчин нэг өрхөд ногдох малын тоо			
	2016	2017	2018	2019	2016	2017	2018	2019
Бүгд	160 650	169 743	169 706	171 605	341	352	351	370
50 хүртэлх малтай	18 874	20 242	20 922	19 780	27	26	26	26
51-200	50 981	52 100	51 394	49 654	124	124	124	124
201-500	55 575	57 776	58 305	58 378	324	325	325	327
501-999	25 459	28 468	29 061	31 669	678	681	682	687
1000-2000	9 166	10 474	9 975	11 404	1 223	1 230	1 227	1 234
2001-ээс дээш малтай	595	683	649	720	2 490	2 521	2 509	2 531

Манай улсын ажил эрхэлдэг дөрвөн хүн тутмын нэг нь 2019 оны байдлаар мал аж ахуйн үйлдвэрлэлд ажиллаж байна. Тухайлбал, мал тооллогын 2019 оны урьдчилсан дүнгээр 285.5 мянган малчид мал аж ахуйн үйлдвэрлэлд ажиллаж байна. Малчдын тоо өмнөх оноос 3.2 мянган малчнаар буюу 1.1 хувиар буурчээ. Нийт малчдын 166.4 мянга буюу 58.3 хувь нь эрэгтэй, 119.1 мянга буюу 41.7 хувь нь эмэгтэй малчид байна. Малчдын дотор эрэгтэй малчид давамгайлж байна.

## МАЛТАЙ БОЛОН МАЛЧИН ӨРХИЙН ТОО, бүс, аймаг, нийслэлээр

Аймаг, нийслэл	Малтай өрх				Малчин өрх				Малчин нэг өрхөд ногдох мал			
	2016	2017	2018	2019	2016	2017	2018	2019	2016	2017	2018	2019
<b>Бүгд</b>	<b>223 761</b>	<b>228 950</b>	<b>230 854</b>	<b>233 317</b>	<b>160 650</b>	<b>169 743</b>	<b>169 706</b>	<b>171 605</b>	<b>341</b>	<b>352</b>	<b>351</b>	<b>370</b>
<b>Баруун бүс</b>	<b>62 019</b>	<b>63 112</b>	<b>63 343</b>	<b>63 836</b>	<b>40 593</b>	<b>42 378</b>	<b>41 445</b>	<b>41 256</b>	<b>319</b>	<b>332</b>	<b>322</b>	<b>328</b>
Баян-Өлгий	14 961	14 976	14 910	14 948	8 888	9 261	8 728	8 703	202	204	201	204
Говь-Алтай	9 932	10 180	10 315	10 521	6 903	7 183	7 106	7 255	442	466	430	429
Завхан	12 931	13 171	13 264	13 392	8 807	9 121	9 078	8 921	330	342	337	364
Увс	12 569	12 909	12 997	13 038	8 588	8 950	8 874	8 932	284	311	315	323
Ховд	11 626	11 876	11 857	11 937	7 407	7 863	7 659	7 445	374	376	347	340
<b>Хангайн бүс</b>	<b>81 614</b>	<b>83 830</b>	<b>84 944</b>	<b>85 694</b>	<b>65 393</b>	<b>69 105</b>	<b>69 123</b>	<b>69 919</b>	<b>323</b>	<b>327</b>	<b>324</b>	<b>345</b>
Архангай	17 797	18 410	18 760	19 102	14 436	15 160	14 978	15 236	316	321	332	367
Баянхонгор	14 162	14 566	14 765	14 914	11 171	11 821	11 920	12 011	340	354	324	350
Булган	10 614	10 685	10 683	10 742	8 301	8 499	8 296	8 526	381	363	361	390
Орхон	1 130	1 217	1 180	1 119	811	881	859	835	129	110	100	123
Өвөрхангай	18 520	18 956	19 209	19 233	15 407	16 087	16 307	16 398	315	335	315	324
Хөвсгөл	19 391	19 996	20 347	20 584	15 267	16 657	16 763	16 913	305	297	316	331
<b>Төвийн бүс</b>	<b>48 415</b>	<b>49 248</b>	<b>49 462</b>	<b>50 118</b>	<b>33 993</b>	<b>35 648</b>	<b>36 005</b>	<b>36 495</b>	<b>382</b>	<b>394</b>	<b>396</b>	<b>428</b>
Говьсүмбэр	1 055	1 041	1 011	1 022	721	712	703	699	484	534	536	565
Дархан-Уул	2 501	2 531	2 366	2 297	1 193	1 371	1 257	1 297	230	196	205	229
Дорноговь	5 141	5 201	5 288	5 351	4 137	4 169	4 234	4 231	390	443	468	518
Дундговь	7 947	8 283	8 466	8 593	6 590	7 001	7 159	7 248	435	485	506	534
Өмнөговь	7 172	7 418	7 496	7 707	5 647	5 819	5 951	6 108	383	427	410	462
Сэлэнгэ	9 565	9 543	9 494	9 554	4 427	4 679	4 850	4 856	300	270	266	290
Төв	15 034	15 231	15 341	15 594	11 278	11 897	11 851	12 056	388	371	362	385
<b>Зүүн бүс</b>	<b>26 443</b>	<b>27 616</b>	<b>28 399</b>	<b>29 011</b>	<b>18 943</b>	<b>20 499</b>	<b>20 811</b>	<b>21 185</b>	<b>391</b>	<b>427</b>	<b>448</b>	<b>462</b>
Дорнод	6 641	7 044	7 295	7 636	4 398	5 028	5 093	5 311	321	348	390	414
Сүхбаатар	9 852	10 073	10 220	10 302	7 256	7 625	7 770	7 901	365	412	429	434
Хэнтий	9 950	10 499	10 884	11 073	7 289	7 846	7 948	7 973	460	493	503	522
<b>Улаанбаатар</b>	<b>5 270</b>	<b>5 144</b>	<b>4 706</b>	<b>4 658</b>	<b>1 728</b>	<b>2 113</b>	<b>2 322</b>	<b>2 750</b>	<b>163</b>	<b>143</b>	<b>127</b>	<b>119</b>



## МАЛЧИД, бүс, аймаг, нийслэлээр

Аймаг, нийслэл	Малчид				Нийт малчдаас эмэгтэй			
	2016	2017	2018	2019	2016	2017	2018	2019
<b>Бүгд</b>	<b>311 373</b>	<b>303 590</b>	<b>288 700</b>	<b>285 482</b>	<b>143 749</b>	<b>133 352</b>	<b>122 860</b>	<b>119 114</b>
<b>Баруун бүс</b>	<b>82 239</b>	<b>79 192</b>	<b>72 395</b>	<b>70 478</b>	<b>38 738</b>	<b>35 351</b>	<b>30 924</b>	<b>29 451</b>
Баян-Өлгий	18 411	17 200	13 993	13 746	8 712	7 350	5 315	4 967
Говь-Алтай	13 691	12 919	12 391	12 287	6 451	5 757	5 406	5 241
Завхан	16 960	16 775	15 953	15 644	8 023	7 740	7 065	6 872
Увс	17 498	17 173	16 130	15 988	8 261	7 740	7 140	7 029
Ховд	15 679	15 125	13 928	12 813	7 291	6 764	5 998	5 342
<b>Хангайн бүс</b>	<b>127 687</b>	<b>124 682</b>	<b>120 381</b>	<b>119 170</b>	<b>59 886</b>	<b>55 847</b>	<b>52 884</b>	<b>51 382</b>
Архангай	27 474	27 055	25 756	25 688	12 849	12 167	11 283	10 980
Баянхонгор	21 990	22 255	21 784	21 771	10 278	10 147	9 816	9 708
Булган	15 579	14 472	13 797	13 917	7 103	6 091	5 675	5 670
Орхон	1 496	1 396	1 352	1 299	710	607	558	552
Өвөрхангай	29 993	28 265	28 103	27 101	14 083	12 417	12 296	11 416
Хөвсгөл	31 155	31 239	29 589	29 394	14 863	14 418	13 256	13 056
<b>Төвийн бүс</b>	<b>61 722</b>	<b>60 290</b>	<b>58 295</b>	<b>57 942</b>	<b>27 655</b>	<b>25 735</b>	<b>24 219</b>	<b>23 671</b>
Говьсүмбэр	1 231	1 164	1 115	1 097	558	509	487	481
Дархан-Уул	2 279	2 297	1 846	1 743	1 050	985	688	568
Дорноговь	7 477	7 232	7 033	7 024	3 257	3 043	2 953	2 958
Дундговь	12 171	12 222	12 136	12 241	5 485	5 361	5 210	5 210
Өмнөговь	9 846	9 635	9 593	9 671	4 503	4 315	4 269	4 237
Сэлэнгэ	8 522	8 278	8 088	7 741	3 888	3 470	3 265	3 008
Төв	20 196	19 462	18 484	18 425	8 914	8 052	7 347	7 209
<b>Зүүн бүс</b>	<b>36 547</b>	<b>36 411</b>	<b>34 508</b>	<b>34 313</b>	<b>16 020</b>	<b>15 335</b>	<b>13 728</b>	<b>13 336</b>
Дорнод	8 471	8 710	7 778	7 983	3 659	3 565	2 817	2 812
Сүхбаатар	14 835	14 775	14 585	14 496	6 582	6 420	6 211	6 140
Хэнтий	13 241	12 926	12 145	11 834	5 779	5 350	4 700	4 384
<b>Улаанбаатар</b>	<b>3 178</b>	<b>3 015</b>	<b>3 121</b>	<b>3 579</b>	<b>1 450</b>	<b>1 084</b>	<b>1 105</b>	<b>1 274</b>

## МАЛЫН ТОО, 2019 оны эцэст, бүс, аймаг, нийслэлээр

Аймаг, нийслэл	2018	2019						Бодод шил- жүүлснээр
	мянган толгой		адуу	үхэр	тэмээ	хонь	ямаа	
<b>Бүгд</b>	<b>66 460.2</b>	<b>70 969.3</b>	<b>4 214.8</b>	<b>4 753.2</b>	<b>472.4</b>	<b>32 267.3</b>	<b>29 261.7</b>	<b>18 712.2</b>
<b>Баруун бүс</b>	<b>15 557.4</b>	<b>16 004.3</b>	<b>734.5</b>	<b>854.6</b>	<b>109.8</b>	<b>6 729.7</b>	<b>7 575.7</b>	<b>3 822.4</b>
Баян-Өлгий	2 166.9	2 192.8	99.0	158.6	5.9	995.9	933.3	549.1
Говь-Алтай	3 513.4	3 597.7	132.4	84.5	44.4	1 066.7	2 269.6	745.1
Завхан	3 555.4	3 849.9	243.7	228.7	8.0	1 950.9	1 418.6	986.9
Увс	3 175.3	3 279.6	130.7	195.7	25.6	1 604.8	1 322.8	797.6
Ховд	3 146.4	3 084.3	128.8	187.1	25.8	1 111.3	1 631.3	743.7
<b>Хангайн бүс</b>	<b>24 323.1</b>	<b>26 246.5</b>	<b>1 530.4</b>	<b>2 076.0</b>	<b>96.1</b>	<b>12 243.5</b>	<b>10 300.4</b>	<b>7 078.7</b>
Архангай	5 482.0	6 167.0	425.9	710.1	1.4	3 321.3	1 708.4	1 905.2
Баянхонгор	4 249.5	4 644.9	189.5	257.6	58.1	1 406.0	2 733.7	1 110.3
Булган	3 305.5	3 641.7	272.0	282.4	1.5	1 923.8	1 162.0	1 022.5
Орхон	114.4	126.9	12.2	19.0	0.1	50.6	45.0	45.4
Өвөрхангай	5 461.3	5 625.5	348.9	292.4	32.7	2 606.8	2 344.6	1 417.9
Хөвсгөл	5 710.4	6 040.4	281.8	514.5	2.4	2 935.1	2 306.7	1 577.4
<b>Төвийн бүс</b>	<b>15 428.5</b>	<b>16 958.7</b>	<b>957.2</b>	<b>809.7</b>	<b>247.7</b>	<b>7 428.9</b>	<b>7 515.1</b>	<b>4 316.1</b>
Говьсүмбэр	427.5	452.0	22.7	14.5	1.0	219.5	194.2	99.6
Дархан-Уул	306.0	347.4	19.3	47.4	0.1	162.3	118.3	108.6
Дорноговь	2 148.1	2 404.2	152.6	91.9	43.5	1 021.6	1 094.6	616.9
Дундговь	3 825.9	4 093.1	178.2	78.2	41.3	1 942.7	1 852.8	873.6
Өмнөговь	2 598.4	3 000.3	109.5	31.7	157.9	718.2	1 983.0	745.6
Сэлэнгэ	1 540.0	1 682.5	103.4	232.3	0.5	744.7	601.6	535.7
Төв	4 582.4	4 979.2	371.4	313.8	3.6	2 619.8	1 670.5	1 336.1
<b>Зүүн бүс</b>	<b>10 739.5</b>	<b>11 315.0</b>	<b>944.6</b>	<b>927.2</b>	<b>18.5</b>	<b>5 688.5</b>	<b>3 736.2</b>	<b>3 314.7</b>
Дорнод	2 377.8	2 629.6	297.4	277.4	6.3	1 262.4	786.2	892.9
Сүхбаатар	3 716.8	3 817.0	321.9	268.5	7.9	1 971.2	1 247.4	1 086.8
Хэнтий	4 644.9	4 868.4	325.4	381.2	4.3	2 454.9	1 702.6	1 335.0
<b>Улаанбаатар</b>	<b>411.8</b>	<b>444.9</b>	<b>48.0</b>	<b>85.7</b>	<b>0.3</b>	<b>176.7</b>	<b>134.2</b>	<b>180.3</b>

## НИЙТ МАЛЫН ДҮНД ТАВАН ТӨРЛИЙН МАЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ

	Малын тоо				Нийт малд 5 төрлийн малын эзлэх			
	2016	2017	2018	2019	2016	2017	2018	2019
	мянган толгой				хувь			
<b>Бүгд</b>	<b>61 549.2</b>	<b>66 219.0</b>	<b>66 460.2</b>	<b>70 969.3</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Адуу	3 635.5	3 939.8	3 940.1	4 214.8	5.9	5.9	5.9	5.9
Үхэр	4 080.9	4 388.5	4 380.9	4 753.2	6.6	6.6	6.6	6.7
Тэмээ	401.3	434.1	459.7	472.4	0.7	0.7	0.7	0.7
Хонь	27 856.6	30 109.9	30 554.8	32 267.3	45.3	45.5	46.0	45.5
Ямаа	25 574.9	27 346.7	27 124.7	29 261.7	41.6	41.3	40.8	41.2

НИЙТ МАЛЫН ДҮНД ТАВАН ТӨРЛИЙН МАЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ,  
2019 оны эцэст, бүс, аймаг, нийслэлээр

Аймаг, нийслэл	Бүгд					
		адуу	үхэр	тэмээ	хонь	ямаа
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>5.9</b>	<b>6.7</b>	<b>0.7</b>	<b>45.5</b>	<b>41.2</b>
<b>Баруун бүс</b>	<b>100.0</b>	<b>4.6</b>	<b>5.3</b>	<b>0.7</b>	<b>42.0</b>	<b>47.3</b>
Баян-Өлгий	100.0	4.5	7.2	0.3	45.4	42.6
Говь-Алтай	100.0	3.7	2.3	1.2	29.7	63.1
Завхан	100.0	6.3	5.9	0.2	50.7	36.8
Увс	100.0	4.0	6.0	0.8	48.9	40.3
Ховд	100.0	4.2	6.1	0.8	36.0	52.9
<b>Хангайн бүс</b>	<b>100.0</b>	<b>5.8</b>	<b>7.9</b>	<b>0.4</b>	<b>46.6</b>	<b>39.2</b>
Архангай	100.0	6.9	11.5	0.0	53.9	27.7
Баянхонгор	100.0	4.1	5.5	1.3	30.3	58.9
Булган	100.0	7.5	7.8	0.0	52.8	31.9
Орхон	100.0	9.6	15.0	0.1	39.8	35.5
Өвөрхангай	100.0	6.2	5.2	0.6	46.3	41.7
Хөвсгөл	100.0	4.7	8.5	0.0	48.6	38.2
<b>Төвийн бүс</b>	<b>100.0</b>	<b>5.6</b>	<b>4.8</b>	<b>1.5</b>	<b>43.8</b>	<b>44.3</b>
Говьсүмбэр	100.0	5.0	3.2	0.2	48.6	43.0
Дархан-Уул	100.0	5.6	13.6	0.0	46.7	34.1
Дорноговь	100.0	6.3	3.8	1.8	42.5	45.5
Дундговь	100.0	4.4	1.9	1.0	47.5	45.3
Өмнөговь	100.0	3.7	1.1	5.3	23.9	66.1
Сэлэнгэ	100.0	6.1	13.8	0.0	44.3	35.8
Төв	100.0	7.5	6.3	0.1	52.6	33.6
<b>Зүүн бүс</b>	<b>100.0</b>	<b>8.3</b>	<b>8.2</b>	<b>0.2</b>	<b>50.3</b>	<b>33.0</b>
Дорнод	100.0	11.3	10.5	0.2	48.0	29.9
Сүхбаатар	100.0	8.4	7.0	0.2	51.6	32.7
Хэнтий	100.0	6.7	7.8	0.1	50.4	35.0
<b>Улаанбаатар</b>	<b>100.0</b>	<b>10.8</b>	<b>19.3</b>	<b>0.1</b>	<b>39.7</b>	<b>30.2</b>

## МАЛ ТӨЛЛӨЛТ, бүс, аймаг, нийслэлээр

Аймаг, нийслэл	Төллөсөн хээлтэгч				Төлөлтийн хувь			
	2016	2017	2018	2019	2016	2017	2018	2019
	мянган толгой							
<b>Бүгд</b>	<b>20 481.4</b>	<b>23 431.3</b>	<b>21 184.9</b>	<b>24 925.1</b>	<b>85.8</b>	<b>88.5</b>	<b>75.0</b>	<b>83.7</b>
<b>Баруун бүс</b>	<b>5 038.5</b>	<b>5 892.3</b>	<b>4 976.5</b>	<b>5 566.0</b>	<b>90.1</b>	<b>93.6</b>	<b>74.9</b>	<b>81.8</b>
Баян-Өлгий	807.7	903.0	844.8	867.8	96.6	98.8	92.2	94.9
Говь-Алтай	1 108.9	1 330.2	950.6	1 179.5	93.6	94.2	62.8	75.1
Завхан	1 111.0	1 267.1	1 037.3	1 321.2	88.2	91.8	71.8	88.0
Увс	931.2	1 149.9	1 156.1	1 176.5	81.0	91.8	86.3	83.0
Ховд	1 079.7	1 242.1	987.7	1 021.0	93.0	92.9	69.2	73.1
<b>Хангайн бүс</b>	<b>7 553.3</b>	<b>8 575.2</b>	<b>7 200.3</b>	<b>9 087.4</b>	<b>86.9</b>	<b>87.4</b>	<b>70.0</b>	<b>83.4</b>
Архангай	1 641.0	1 903.6	1 736.1	2 036.6	86.1	89.0	77.7	86.1
Баянхонгор	1 223.3	1 521.2	816.6	1 476.8	79.9	87.4	44.7	75.5
Булган	1 231.0	1 346.2	1 079.5	1 329.7	85.2	85.5	71.0	84.3
Орхон	45.0	52.1	35.6	53.5	81.7	86.0	62.8	97.0
Өвөрхангай	1 709.4	1 955.9	1 657.8	2 158.7	94.2	93.5	72.5	90.4
Хөвсгөл	1 703.6	1 796.2	1 874.6	2 032.1	87.7	81.6	79.4	79.7
<b>Төвийн бүс</b>	<b>4 627.6</b>	<b>5 273.1</b>	<b>4 908.2</b>	<b>5 810.3</b>	<b>80.6</b>	<b>84.3</b>	<b>74.1</b>	<b>82.7</b>
Говьсүмбэр	157.2	171.5	170.5	171.5	91.8	92.4	84.6	84.3
Дархан-Уул	121.4	124.6	123.5	143.1	87.4	80.2	80.7	96.1
Дорноговь	550.6	643.0	672.2	759.6	71.2	83.9	79.4	81.7
Дундговь	994.0	1 234.8	1 319.3	1 424.4	86.8	94.1	87.8	86.1
Өмнөговь	540.7	663.6	415.0	785.5	64.0	68.9	38.9	66.9
Сэлэнгэ	599.9	554.6	604.0	614.2	88.6	75.6	83.3	84.5
Төв	1 663.9	1 881.1	1 603.8	1 911.9	83.7	87.9	75.4	87.4
<b>Зүүн бүс</b>	<b>3 091.7</b>	<b>3 512.6</b>	<b>3 927.6</b>	<b>4 289.5</b>	<b>84.6</b>	<b>89.8</b>	<b>87.4</b>	<b>88.2</b>
Дорнод	582.5	670.7	836.2	901.2	84.0	88.8	89.8	86.0
Сүхбаатар	1 014.5	1 188.6	1 312.4	1 389.9	76.0	87.0	86.0	85.1
Хэнтий	1 494.7	1 653.2	1 779.0	1 998.4	91.9	92.3	87.4	91.7
<b>Улаанбаатар</b>	<b>170.3</b>	<b>178.2</b>	<b>172.3</b>	<b>171.9</b>	<b>90.6</b>	<b>86.5</b>	<b>85.2</b>	<b>85.9</b>

## ТӨЛ БОЙЖИЛТ, бүс, аймаг, нийслэлээр

Аймаг, нийслэл	Бойжуулсан төл				Бойжилтын хувь			
	2016	2017	2018	2019	2016	2017	2018	2019
	мянган толгой							
<b>Бүгд</b>	<b>19 721.7</b>	<b>22 642.0</b>	<b>19 403.3</b>	<b>23 587.0</b>	<b>95.9</b>	<b>96.2</b>	<b>91.3</b>	<b>94.4</b>
<b>Баруун бүс</b>	<b>4 763.2</b>	<b>5 718.1</b>	<b>4 541.7</b>	<b>5 107.5</b>	<b>94.3</b>	<b>96.8</b>	<b>91.2</b>	<b>91.6</b>
Баян-Өлгий	789.8	856.8	749.6	809.2	97.6	94.8	88.7	93.2
Говь-Алтай	1 080.6	1 307.0	919.0	1 123.4	97.0	97.8	96.5	94.9
Завхан	1 049.5	1 235.1	1 000.8	1 305.5	94.4	97.4	96.4	98.8
Увс	797.8	1 112.6	991.9	1 038.9	85.5	96.5	85.7	88.2
Ховд	1 045.4	1 206.5	880.2	830.5	96.7	97.0	89.1	81.3
<b>Хангайн бүс</b>	<b>7 322.5</b>	<b>8 196.1</b>	<b>6 543.5</b>	<b>8 706.7</b>	<b>96.9</b>	<b>95.5</b>	<b>90.8</b>	<b>95.8</b>
Архангай	1 592.5	1 796.7	1 582.7	1 964.7	97.0	94.4	91.2	96.5
Баянхонгор	1 178.5	1 488.6	744.7	1 438.1	96.2	97.7	91.2	97.3
Булган	1 190.7	1 296.3	1 045.3	1 311.9	96.6	96.1	96.8	98.6
Орхон	44.9	50.0	34.7	53.4	99.6	95.7	97.4	99.7
Өвөрхангай	1 678.5	1 890.5	1 338.7	2 000.6	98.1	96.6	80.8	92.7
Хөвсгөл	1 637.4	1 674.0	1 797.3	1 938.0	96.0	93.1	95.8	95.3
<b>Төвийн бүс</b>	<b>4 508.9</b>	<b>5 209.8</b>	<b>4 557.5</b>	<b>5 713.8</b>	<b>96.5</b>	<b>97.6</b>	<b>92.0</b>	<b>97.7</b>
Говьсүмбэр	153.1	170.2	138.0	166.9	95.4	98.4	80.3	96.8
Дархан-Уул	121.5	119.4	123.1	143.0	99.6	95.6	99.6	99.7
Дорноговь	518.3	655.3	659.7	760.3	92.9	99.7	96.3	98.9
Дундговь	974.7	1249.1	1 173.7	1 410.9	96.6	99.1	87.8	98.4
Өмнөговь	540.5	664.3	400.0	787.7	99.4	99.1	96.1	99.7
Сэлэнгэ	599.0	530.0	595.7	608.5	99.6	95.4	98.4	98.9
Төв	1 602.0	1 821.6	1 467.3	1 836.5	95.5	96.2	90.9	95.3
<b>Зүүн бүс</b>	<b>2 960.9</b>	<b>3 343.9</b>	<b>3 594.1</b>	<b>3 891.5</b>	<b>95.3</b>	<b>94.6</b>	<b>91.0</b>	<b>90.4</b>
Дорнод	575.5	657.2	827.3	884.4	98.4	97.4	98.5	97.7
Сүхбаатар	994.8	1 189.1	1 274.5	1 328.6	97.4	99.4	96.3	95.3
Хэнтий	1 390.6	1 497.6	1 492.2	1 678.5	92.6	90.1	83.6	83.7
<b>Улаанбаатар</b>	<b>166.2</b>	<b>174.1</b>	<b>166.5</b>	<b>167.5</b>	<b>97.4</b>	<b>96.5</b>	<b>96.5</b>	<b>97.4</b>

## ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, бүс, аймаг, нийслэлээр

Аймаг, нийслэл	Хорогдсон том мал				Оны эхний малд том малын хорогдлын эзлэх хувь			
	2016	2017	2018	2019	2016	2017	2018	2019
	мянган толгой							
<b>Бүгд</b>	<b>1 452.1</b>	<b>888.0</b>	<b>2 635.4</b>	<b>1 117.6</b>	<b>2.6</b>	<b>1.4</b>	<b>4.0</b>	<b>1.7</b>
<b>Баруун бүс</b>	<b>452.3</b>	<b>130.2</b>	<b>706.3</b>	<b>417.5</b>	<b>3.3</b>	<b>3.3</b>	<b>4.4</b>	<b>2.7</b>
Баян-Өлгий	30.9	17.8	71.0	60.4	1.5	0.8	3.2	2.8
Говь-Алтай	35.1	10.9	151.2	57.7	1.2	0.3	4.0	1.6
Завхан	131.2	40.6	181.0	22.5	4.2	1.2	5.0	0.6
Увс	198.1	30.6	127.8	145.0	7.3	1.1	4.1	4.6
Ховд	57.1	30.3	175.3	131.9	2.0	0.9	5.1	4.2
<b>Хангайн бүс</b>	<b>407.1</b>	<b>472.3</b>	<b>1 206.3</b>	<b>328.8</b>	<b>2.0</b>	<b>2.0</b>	<b>4.9</b>	<b>1.4</b>
Архангай	147.4	129.5	319.4	63.8	3.3	2.6	6.0	1.2
Баянхонгор	120.5	22.4	338.4	41.0	3.2	0.5	7.4	1.0
Булган	58.2	85.4	115.9	26.2	1.8	2.5	3.4	0.8
Орхон	0.5	5.4	6.4	0.5	0.4	4.0	5.2	0.5
Өвөрхангай	37.8	29.3	352.3	103.6	0.8	0.6	6.1	1.9
Хөвсгөл	42.6	200.3	73.9	93.8	1.0	3.9	1.4	1.6
<b>Төвийн бүс</b>	<b>339.1</b>	<b>184.2</b>	<b>435.8</b>	<b>112.3</b>	<b>2.6</b>	<b>2.6</b>	<b>2.9</b>	<b>0.7</b>
Говьсүмбэр	14.7	2.9	39.5	5.7	3.9	0.7	9.0	1.3
Дархан-Уул	1.6	19.1	3.7	0.9	0.6	5.9	1.2	0.3
Дорноговь	118.0	5.6	18.9	8.7	6.6	0.3	0.9	0.4
Дундговь	69.7	3.4	75.4	14.2	2.5	0.1	2.1	0.4
Өмнөговь	10.1	11.3	62.0	8.1	0.5	0.5	2.3	0.3
Сэлэнгэ	3.3	69.6	14.6	6.7	0.2	4.4	1.0	0.4
Төв	121.6	72.4	221.6	68.1	2.7	1.5	4.7	1.5
<b>Зүүн бүс</b>	<b>247.2</b>	<b>93.0</b>	<b>271.8</b>	<b>254.2</b>	<b>3.0</b>	<b>3.0</b>	<b>2.7</b>	<b>2.4</b>
Дорнод	13.6	9.1	6.6	7.4	0.9	0.5	0.3	0.3
Сүхбаатар	185.6	12.9	76.0	46.6	6.0	0.4	2.2	1.3
Хэнтий	48.0	70.9	189.2	200.2	1.4	1.8	4.3	4.3
<b>Улаанбаатар</b>	<b>6.4</b>	<b>8.3</b>	<b>15.1</b>	<b>4.7</b>	<b>1.6</b>	<b>1.9</b>	<b>3.6</b>	<b>1.1</b>

## ӨВЧНӨӨР ХОРОГДСОН МАЛ, бүс, аймаг, нийслэлээр

Аймаг, нийслэл	Өвчнөөр хорогдсон мал				Зүй бус хорогдолд өвчний хорогдлын эзлэх хувь			
	2016	2017	2018	2019	2016	2017	2018	2019
	мянган толгой							
<b>Бүгд</b>	<b>73.8</b>	<b>81.6</b>	<b>68.6</b>	<b>79.2</b>	<b>5.1</b>	<b>9.2</b>	<b>2.6</b>	<b>7.1</b>
<b>Баруун бүс</b>	<b>30.5</b>	<b>9.5</b>	<b>13.8</b>	<b>10.3</b>	<b>6.7</b>	<b>7.3</b>	<b>1.9</b>	<b>2.5</b>
Баян-Өлгий	1.8	1.6	3.2	3.0	6.0	8.8	4.4	5.0
Говь-Алтай	1.3	1.4	0.7	0.4	3.7	12.7	0.5	0.7
Завхан	0.4	1.1	0.1	0.1	0.3	2.6	0.0	0.3
Увс	13.4	4.8	9.2	5.9	6.7	15.6	7.2	4.1
Ховд	13.6	0.7	0.6	0.9	23.8	2.3	0.4	0.7
<b>Хангайн бүс</b>	<b>15.1</b>	<b>31.2</b>	<b>30.5</b>	<b>32.5</b>	<b>3.7</b>	<b>6.6</b>	<b>2.5</b>	<b>9.9</b>
Архангай	8.0	17.6	10.0	8.2	5.4	13.6	3.1	12.8
Баянхонгор	0.0	0.3	0.1	2.2	0.0	1.2	0.0	5.4
Булган	3.1	3.9	2.9	6.1	5.3	4.5	2.5	23.2
Орхон	0.0	0.0	0.1	0.1	4.4	0.0	1.1	13.0
Өвөрхангай	2.4	2.4	14.5	8.9	6.3	8.3	4.1	8.6
Хөвсгөл	1.6	7.1	2.9	7.1	3.8	3.5	3.9	7.5
<b>Төвийн бүс</b>	<b>18.3</b>	<b>25.8</b>	<b>18.4</b>	<b>15.1</b>	<b>5.4</b>	<b>14.0</b>	<b>4.2</b>	<b>13.4</b>
Говьсүмбэр	0.0	0.3	0.1	0.1	0.3	10.3	0.2	2.6
Дархан-Уул	0.3	0.1	0.0	0.1	20.3	0.6	0.4	14.3
Дорноговь	4.5	2.6	2.4	0.7	3.8	45.9	12.9	8.7
Дундговь	0.7	1.5	2.9	1.8	1.0	46.0	3.9	12.4
Өмнөговь	1.0	0.4	2.4	0.3	10.2	3.5	3.9	3.9
Сэлэнгэ	0.4	8.3	0.6	0.3	13.1	11.9	4.0	5.0
Төв	11.3	12.6	9.9	11.7	9.3	17.5	4.5	17.1
<b>Зүүн бүс</b>	<b>8.8</b>	<b>14.0</b>	<b>5.1</b>	<b>21.0</b>	<b>3.6</b>	<b>15.0</b>	<b>1.9</b>	<b>8.3</b>
Дорнод	1.4	1.7	0.4	0.6	10.3	18.2	6.3	8.6
Сүхбаатар	0.7	4.6	0.1	0.2	0.4	35.9	0.2	0.5
Хэнтий	6.7	7.6	4.6	20.2	13.9	10.8	2.4	10.1
<b>Улаанбаатар</b>	<b>1.1</b>	<b>1.1</b>	<b>0.8</b>	<b>0.3</b>	<b>16.7</b>	<b>13.1</b>	<b>5.4</b>	<b>6.3</b>

## 3. ГАЗАР ТАРИАЛАН



Газар тариалангийн салбарт тариалан эрхэлдэг нийт 14728 өрх, 1401 аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Тариалан эрхэлдэг өрхийн 43.1 хувь нь Төвийн бүсэд, 19.4 хувь нь Баруун, 19.1 хувь нь Хангайн, 9.4 хувь нь Улаанбаатар, 9.0 хувь нь Зүүн бүсэд байна. Харин тариалан эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын 54.8 хувь нь Төвийн бүсэд, 21.8 хувь нь Хангайн, 11.0 хувь нь Баруун, 9.0 хувь нь Зүүн, 3.4 хувь нь Улаанбаатар хотод байна.

Улсын хэмжээнд 2019 онд нийт 523.1 мянган га талбайд тариалалт хийсэн нь өмнөх оноос 15.1 (3.0%) мянган га-гаар өссөн байна.

## Тариалсан талбай, ургамлын төрлөөр

	2016	2017	2018	2019	<u>2019</u> <u>2018</u>
	мянган га				хувь
Бүгд	505.3	524.3	507.9	523.1	103.0
Үр тариа	377.8	390.9	366.8	369.4	100.7
Бүүдэй	355.1	365.7	342.4	343.5	100.3
Төмс	15.0	15.1	12.9	14.9	115.6
Хүнсний ногоо	9.1	8.4	8.9	8.4	95.2
Тэжээлийн ургамал	29.9	26.2	46.3	43.8	94.6
Бусад	73.1	85.5	75.3	86.5	114.8

Нийт тариалсан талбайн 369.4 (70.6%) мянган га-д үр тариа, 43.8 (8.4%) мянган га-д тэжээлийн ургамал, 14.9 (2.9%) мянган га-д төмс, 8.4 (1.6%) мянган га-д хүнсний ногоо тус тус тариалсан нь өмнөх оноос үр тариа 2.6 (0.7%) мянган га, төмс 2.0 (15.6%) мянган га-гаар өсөж, харин тэжээлийн ургамал 2.5 (5.4%) мянган га, хүнсний ногоо 0.4 (4.8%) мянган га-гаар тус тус буурсан байна.

Нийт болон үр тариа тариалсан талбайг 1990-2019 оноор авч үзэхэд, 1990 онд хамгийн их талбайд буюу 787.8 мянган га-д тариалалт хийж, 2006 онд хамгийн бага буюу 164.6 мянган га талбайд тариалжээ. Харин 1990-2004 онд үр тариа нь нийт тариалсан талбайн дунджаар 89.0- 94.0 хувийг эзэлж байсан бол сүүлийн 15 жилд буюу 2005-2019 онд үр тарианы тариалсан талбай нь нийт тариалсан талбайн дунджаар 73.3-78.1 хувийг эзэлж байна. Эндээс харахад газар тариалангийн голлох бүтээгдэхүүн үр тариа хэвээр байгаа боловч нийт талбайд эзлэх дүн буурч, газар тариалангийн бусад бүтээгдэхүүн (хүнсний ногоо, тэжээлийн ургамал, техникийн ургамал)- ний нэр төрөл нэмэгдэж байна.

Үр тариа тариалсан талбай өмнөх оноос Ховд, Говь-Алтай, Завхан, Хөвсгөл, Өвөрхангай, Увс, Архангай, Дархан-Уул, Сэлэнгэ, Дорнод аймагт 49.9 га-гаас 5.1 мянган га буюу 2.2-72.6 хувиар өссөн бол бусад аймагт 0.7 га-гаас 8.2 мянган га буюу 3.2-42.6 хувиар буурчээ.



Төмс тариалсан талбайг өмнөх онтой харьцуулахад Дундговь, Говьсүмбэр, Улаанбаатар хот, Сүхбаатар, Орхон, Архангай, Өвөрхангай, Булган, Сэлэнгэ, Төв аймагт 1.7 га-гаас 2.2 мянган га буюу 2.3-37.9 хувиар өсөж, бусад аймагт 4.2-85.5 га буюу 2.0-49.4 хувиар буурчээ.

Хүнсний ногоо тариалсан талбай өмнөх оноос Дундговь, Сүхбаатар, Говьсүмбэр, Баянхонгор, Архангай, Завхан, Өвөрхангай, Ховд, Дархан-Уул аймагт 1.3-97.2 га буюу 4.9-44.8 хувиар өсөж, бусад аймагт 2.6-209.0 га буюу 0.9-52.3 хувиар буурчээ.

Үр тариа 2019 онд 433.3 мянган тонн, төмс 192.2 мянган тонн, хүнсний ногоо 99.5 мянган тонн, тэжээлийн ургамал 121.1 мянган тонн, техникийн ургамал 34.0 мянган тонныг хураан авч, 1.4 сая тонн хадлан, 58.4 мянган тонн гар тэжээл бэлтгэсэн байна.

	2016	2017	2018	2019	<u>2019</u> 2018
	мянган тонн				хувь
Үр тариа	483.5	238.1	453.8	433.3	95.5
Улаан буудай	467.1	231.4	436.1	411.4	94.3
Арвай	6.5	1.7	2.4	2.5	104.7
Овьёос	7.9	3.5	10.0	13.3	133.1
Төмс	165.3	121.8	168.9	192.2	113.8
Хүнсний ногоо	94.4	82.1	100.7	99.5	98.9
Тэжээлийн ургамал	53.4	47.9	123.8	121.1	97.8
Техникийн ургамал	5.5	13.9	23.9	34.0	142.4
Бэлтгэсэн хадлан	1 275.4	1 008.1	1 229.4	1 369.2	111.4
Гар тэжээл	45.8	52.3	51.7	58.4	113.1


Өмнөх оноос хураасан үр тариа 20.5 (4.5%) мянган тонн, тэжээлийн ургамал 2.7 (2.2%) мянган тонноор, хүнсний ногоо 1.2 (1.1%) мянган тонноор буурч, харин бэлтгэсэн хадлан 139.8 (11.4%) мянган тонн, төмс 23.3 (13.8%) мянган тонн, бэлтгэсэн гар тэжээл 6.7 (13.1%) мянган тонноор өссөн байна. Хураасан үр тарианы 94.9 хувь нь улаан буудай, 3.1 хувь нь овьёос, 0.6 хувь нь арвай байна.

Хураасан үр тариа Говь-Алтай, Төв, Хөвсгөл, Дархан-Уул, Өвөрхангай, Архангай, Увс, Дорнод аймагт 0.3-6.4 мянган тонн буюу 0.5-90.1 хувиар өсөж, бусад аймагт 2.1 тонноос 31.6 мянган тонн буюу 1.9-76.0 хувиар буурчээ.

#### 4.ХӨДӨӨ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ДУНДАЖ ҮНЭ

Малын зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2019 оны 12 дүгээр сард нас гүйцсэн эр хонины дундаж үнэ Орхон аймагт хамгийн их буюу 220.0 мянган төгрөг, Дорнод аймагт хамгийн бага буюу 125.7 мянган төгрөг байна.

##### Эр хонины дундаж үнэ, 2019 оны 12 дугаар сард, аймаг, нийслэлээр, мянган төгрөгөөр



Малын зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2019 оны 12 дугаар сард ат 1.0 сая төгрөг, хязаалан шар 1.0 сая төгрөг, соёолон үрээ 862.1 мянган төгрөг, эр хонь 157.7 мянган төгрөг, эр ямаа 115.8 мянган төгрөг байна.

Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2019 оны 12 дугаар сард 2 метрээс дээш урттай үхрийн шир 8.1 мянган төгрөг, ямааны цагаан ноолуур 58.5 мянган төгрөг байна

Газар тариалангийн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2019 оны 12 дугаар сард боодолтой өвсний (20кг) үнэ Өвөрхангай аймагт хамгийн их буюу 11.3 мянган төгрөг, Дорнод аймагт хамгийн бага буюу 4.0 мянган төгрөг байна.